



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Наран сумын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2023/91/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баруун-Урт сум

2023 он

Миндүг Аудит ХХК
Гүйцэтгэх захирал С.Энхтөр
Утас: 95957791
Цахим хаяг: director@mindug.mn

Аудитын менежер Ц.Номингоо
Утас: 90098901
Цахим хаяг: soo@mindug.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	3
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.5.1 Завсрын аудитын талаар	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
5.1 Залруулга	Error! Bookmark not defined.
5.2 Зөвлөмж	15
5.3 Албан шаардлага	15

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УТХО	Улсын Төсвийн Хөрөнгө Оруулалт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

**СҮХБААТАР АЙМГИЙН НАРАН СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Ө.БОРГИЛ
ТАНАА**

2023.02.25 № 116

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн “Наран сумын Ерөнхий боловсролын сургууль”-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн “Наран сумын Ерөнхий боловсролын сургууль”-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй байна.

2021онд төсвөөс 502,044.2 мянган төгрөг орон нутгийн санхүүжилтээр 38,725.8 мянган төгрөг авахаар батлагдсан нь өмнөх оны батлагдсан төсвөөс 59,242.0 мянган төгрөгөөр нэмэгдэж батлагдсан нь 95 хувийн гүйцэтгэлтэй байна.

Аудитын гол асуудал

Дээд шатны төсвийн захирагчаас батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын 10 зорилтын хүрээнд 48 арга хэмжээг хэрэгжүүлэхээр ТШЗ-аас 662,581.5 мянган төгрөг батлагдаж гүйцэтгэлээр 661,779.4 мянган төгрөг, Орон нутгийн санхүүжилтээс 88,651.1 мянган төгрөг батлагдан гүйцэтгэлээр 84,033.5 мянган төгрөгийг зарцуулсан буюу төлөвлөгөөний хэрэгжилт 95%-тай байгааг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд толилуулаагүй асуудал ажиглагдаагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн. Үйл ажиллагааны тайлан, бусад мэдээлэлд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	71,371,633.94	102,043,314.43
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	24,272,103.41
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	24,272,103.41
3121	Төгрөг	-	24,272,103.41
31211	Төрийн сангийн харилцах	-	24,272,103.41
35	БАРАА МАТЕРИАЛ	71,371,633.94	77,771,211.02
351	Түүхий эд материал	1,276,760.00	534,900.00
35130	Эм боох материал	1,276,760.00	534,900.00
354	Хангамжийн материал	55,424,873.94	61,616,311.02
35410	Бичиг хэргийн материал	711,210.00	467,210.00
35420	Аж ахуйн материал	45,884,365.04	52,730,336.04
35440	Түлш, шатах тослох материал	1,156,657.40	48.48
35460	Хүнсний материал	934,150.00	1,680,225.00
35470	Бусад хангамжийн материал	6,738,491.50	6,738,491.50
35600	Мал амьтад	14,670,000.00	15,620,000.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	712,715,274.81	1,430,750,698.53
392	Биет хөрөнгө	694,571,274.81	1,411,306,698.53
39201	Барилга, байгууламж, орон сууц	739,933,603.00	1,329,690,428.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(62,943,580.08)	(83,637,436.32)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	37,000,000.00	37,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(37,000,000.00)	(37,000,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	104,818,701.27	136,959,833.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(98,913,145.75)	(8,117,880.31)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	37,237,866.67	48,898,625.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(27,027,160.78)	(13,951,861.32)
39214	Бусад үндсэн хөрөнгө	8,575,701.20	8,575,701.20
39215	Хуримтлагдсан элэгдэл	(8,575,701.20)	(8,575,701.20)
39217	Ном	1,464,990.48	1,464,990.48
393	Биет бус хөрөнгө	18,144,000.00	19,444,000.00
39301	Программ хангамж	775,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(775,000.00)	(200,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	18,144,000.00	18,144,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	784,086,908.75	1,532,794,012.96
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,880,707.70	4,293,345.73
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,880,707.70	4,293,345.73
413	Өглөг	1,880,707.70	4,293,345.73
4136	Бусад өглөг	1,880,707.70	4,293,345.73
41361	Байгууллагад төлөх өглөг	1,880,707.70	3,537,495.73
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	755,850.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	782,206,201.05	1,528,500,667.23
51	Засгийн газрын хувь оролцоо	782,206,201.05	1,528,500,667.23
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,140,270,606.97	1,140,270,606.97
51101	Өмч: - төрийн	1,140,270,606.97	1,140,270,606.97
512	Хуримтлагдсан үр дүн	(358,084,405.92)	388,210,060.26
51210	Өмнөх үеийн үр дүн	(358,084,405.92)	(358,084,405.92)
51220	Тайлант үеийн үр дүн	-	746,294,466.18
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	20,000.00	20,000.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	784,086,908.75	1,532,794,012.96

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	564,580,353.52	1,506,132,633.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	19,022,317.52	740,938,614.00
120	Нийтлэг татварын бус орлого	19,022,317.52	740,938,614.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	19,022,317.52	740,938,614.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,804,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	19,022,317.52	739,134,614.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	50,095,903.00	765,194,019.80
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	681,160,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	681,160,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	495,462,133.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,140,036.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,140,036.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	45,886,450.00	84,033,519.80
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	45,886,450.00	84,033,519.80
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	69,417.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	69,417.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	575,982,067.70	759,550,830.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	575,982,067.70	759,550,830.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	549,658,600.40	713,587,210.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	416,595,250.00	499,538,171.01
210101	Үндсэн цалин	317,020,717.00	393,044,103.43
210102	Нэмэгдэл	71,071,071.00	89,943,424.84
210104	Урамшуулал	28,503,462.00	16,550,642.74
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,915,500.00	61,245,910.38
210201	Тэтгэврийн даатгал	32,689,700.00	41,430,899.07
210202	Тэтгэмжийн даатгал	3,556,900.00	5,027,287.10
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,845,000.00	4,007,083.17
210204	Ажилгүйдлийн даатгал	711,000.00	963,328.64
210205	Эрүүл мэндийн даатгал	7,112,900.00	9,817,312.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,728,884.00	47,702,245.45
210301	Гэрэл, цахилгаан	4,106,928.00	4,819,879.53
210302	Түлш, халаалт	29,957,656.00	39,328,065.92
210303	Цэвэр, бохир ус	2,664,300.00	3,554,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,290,116.00	11,227,070.50
210401	Бичиг хэрэг	1,235,416.00	621,500.00
210402	Тээвэр, шатахуун	523,900.00	270,851.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	375,000.00	-
210404	Ном, хэвлэл	944,100.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	88,700.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,123,000.00	-
210408	Бараа материал акталсны зардал	-	10,334,719.00
2105	Нормативт зардал	5,146,005.00	26,259,875.00

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	500,490.00	1,142,485.00
210502	Хоол, хүнс	4,103,475.00	25,117,390.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	542,040.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,157,950.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	2,157,950.00	5,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	282,000.00	-
210702	Дотоод албан томилолт	282,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	300,200.00	6,213,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300,200.00	1,525,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	4,687,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,242,695.40	56,400,538.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,362,700.00	25,234,094.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,225,900.00	4,201,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	31,654,095.40	26,964,644.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,323,467.30	45,963,620.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,726,140.00	45,963,620.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	8,000.00	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	636,800.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	19,081,340.00	39,869,720.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	6,093,900.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	431,267.30	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	431,267.30	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,166,060.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,166,060.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(11,401,714.18)</u>	<u>746,581,803.06</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	287,336.88
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	287,336.88
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(287,336.88)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(11,401,714.18)</u>	<u>746,294,466.18</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	545,558,036.00	767,521,719.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	1,525,700.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	1,525,700.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	1,525,700.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,525,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	545,558,036.00	765,996,019.80
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	681,962,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	681,962,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	495,462,133.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,140,036.00	00.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,140,036.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	45,886,450.00	84,033,519.80
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	45,886,450.00	84,033,519.80
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	69,417.00	00.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	69,417.00	00.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	544,778,036.00	720,507,116.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	544,778,036.00	720,507,116.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	521,495,558.70	673,211,571.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	417,101,300.00	500,524,190.21
210101	Үндсэн цалин	318,701,800.00	389,606,849.88
210102	Нэмэгдэл	73,868,100.00	94,316,872.33
210104	Урамшуулал	24,531,400.00	16,600,468.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,915,500.00	61,281,891.18
210201	Тэтгэврийн даатгал	32,689,700.00	41,466,899.07
210202	Тэтгэмжийн даатгал	3,556,900.00	5,008,866.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,845,000.00	4,007,083.17
210204	Ажилгүйдлийн даатгал	711,000.00	981,748.94
210205	Эрүүл мэндийн даатгал	7,112,900.00	9,817,293.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,294,532.70	47,684,800.00
210301	Гэрэл, цахилгаан	4,106,928.00	4,819,879.53
210302	Түлш, халаалт	26,385,304.70	39,362,620.47
210303	Цэвэр, бохир ус	2,802,300.00	3,502,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,497,586.00	00.00
210401	Бичиг хэрэг	1,175,086.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	794,800.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	375,000.00	00.00
210404	Ном, хэвлэл	944,100.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	88,700.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,119,900.00	00.00
2105	Нормативт зардал	9,044,240.00	20,530,690.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	841,500.00	00.00
210502	Хоол, хүнс	7,434,040.00	20,530,690.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	768,700.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	282,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	282,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	592,600.00	6,213,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	592,600.00	1,525,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	4,687,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,767,800.00	31,976,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	27,395,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,767,800.00	4,581,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,282,477.30	47,295,545.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,685,150.00	47,295,545.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	636,800.00	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,048,350.00	41,201,645.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	6,093,900.00

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	431,267.30	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	431,267.30	00.00
213404	Хөрөнгийн	00.00	00.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,166,060.00	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,166,060.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	780,000.00	47,014,603.41
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	780,000.00	22,742,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	780,000.00	22,742,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	780,000.00	22,742,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	780,000.00	22,742,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-780,000.00	-22,742,500.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	24,272,103.41
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	24,272,103.41

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,140,270,606.97	-346,654,691.74	793,615,915.23
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,140,270,606.97	-346,654,691.74	793,615,915.23
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	-11,401,714.18	-11,401,714.18
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,140,270,606.97	-358,064,405.92	782,206,201.05
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,140,270,606.97	-358,064,405.92	782,206,201.05
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,140,270,606.97	-358,064,405.92	782,206,201.05
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	746,294,466.18	746,294,466.18
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,140,270,606.97	388,230,060.26	1,528,500,667.23

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	772,417,600.00	743,249,616.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	772,417,600.00	743,249,616.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	722,691,200.00	695,430,371.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	512,581,200.00	500,524,190.21
210101	Үндсэн цалин	392,855,900.00	389,606,849.88
210102	Нэмэгдэл	105,322,000.00	94,316,872.33
210104	Урамшуулал	14,403,300.00	16,600,468.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,127,900.00	61,281,891.18
210201	Тэтгэврийн даатгал	43,606,900.00	41,466,899.07
210202	Тэтгэмжийн даатгал	5,130,400.00	5,008,866.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,104,100.00	4,007,083.17
210204	Ажилгүйдлийн даатгал	1,026,200.00	981,748.94
210205	Эрүүл мэндийн даатгал	10,260,300.00	9,817,866.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	52,302,300.00	47,684,800.00
210301	Гэрэл, цахилгаан	6,000,000.00	4,819,879.53
210302	Түлш, халаалт	43,500,000.00	39,362,620.47

210303	Цэвэр, бохир ус	2,802,300.00	3,502,300.00
2105	Нормативт зардал	27,467,600.00	20,530,690.00
210502	Хоол, хүнс	27,467,600.00	20,530,690.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,491,700.00	6,213,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,804,000.00	1,525,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,687,700.00	4,687,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,720,500.00	54,719,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	47,689,000.00	47,687,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,031,500.00	7,031,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,726,400.00	47,295,545.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	49,726,400.00	47,295,545.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	43,632,500.00	41,201,645.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,093,900.00	6,093,900.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	772,417,600.00	767,521,719.80
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	662,581,500.00	681,962,500.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	-	681,962,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	662,581,500.00	-
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	88,651,100.00	84,033,519.80
132001	Орон нутгийн төсвөөс	88,651,100.00	84,033,519.80
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,804,000.00	1,527,700.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,804,000.00	1,527,700.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	24,272,103.59

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Наран сумын Ерөнхий боловсролын сургууль нь мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн ерөнхий суурь чадамжтай иргэн төлөвшүүлэх үйл ажиллагаа явуулдаг Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Байгууллагын чиг үүрэг:

- Бага боловсрол: Эх хэлний суурь чадамжтай, бүтээлч, сурах арга барилтай хүүхэд төлөвшүүлэх
- Суурь боловсрол: Амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар эзэмшсэн, бие даан бүтээлчээр суралцах чадамжтай иргэн төлөвшүүлэх
- Бүрэн дунд боловсрол: Мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн суурь чадамжтай иргэн төлөвшүүлэх

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

- Сангийн яамны 2023 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 10/84 тоот албан тоот “Төсвийн тухай хуулийн дагуу 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Наран сумын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймгийн Наран сумын сургууль нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 748,707.1 мянган төгрөгөөр буюу 48.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	24,272.1	24,272.1
Бараа материал	71,371.6	77,771.2	6,399.5
Үндсэн хөрөнгө	712,715.2	1,430,750.6	718,035.4
Нийт хөрөнгө	748,086.9	1,532,794.0	748,707.1
Өр төлбөр	1,880.7	4,293.3	2,412.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	782,206.2	1,528,500.6	746,294.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	748,086.9	1,532,794.0	748,707.1

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 24,272.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд үлдэгдэл санхүүжилтийг төвлөрүүлээгүй нь нөлөөлжээ. Бараа материалын үлдэгдэл 77,771.2 мянган төгрөг болж 6,399.5 мянган төгрөгөөр буюу 8.2 хувиар өссөн байна. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,430,750.6 мянган төгрөг болж, 718,035.4 мянган төгрөгөөр буюу

50.2 хувиар өссөн нь дотуур байрны барилга 590,331.4 мянган төгрөгөөр шилжүүлэн авсанаас голлон шалтгаалжээ.

Өр төлбөрийн үлдэгдэл нь 2,412.6 мянган төгрөг болж өссөн нь аж ахуйн материалын худалдан авсны төлбөр төлөгдөөгүй улмаас 56.2 хувиар өссөн байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 941,552.2 мянган төгрөг буюу 62.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан орлого байна. Цэцэрлэгийн барилга 739,134.6 мянган төгрөгийг үнэ төлбөргүй орлого хүлээн авснаас гол шалтгаалжээ.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал өмнөх оноос 183,568.7 мянган төгрөг буюу 24.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, хоол хүнс, гэрэл цахилгаантай холбоотой зардал байна. Цалингийн зардал 76,023.3, түлш халаалт 9,370.4, цэвэр, бохир ус 890.0, хоол, хүнс 21,537.6 мянган төгрөгөөр өссөн нь үйл ажиллагааг өргөжүүлэхийн тулд багш, сурган хүмүүжүүлэгчийн тоог нэмэгдүүлж, хүүхдийг эрүүл аюулгүй орчинд сурч хүмүүжихийг эрхэмлэж чанартай хоол хүнс, дулаан орчин бүрдүүлж, үйл ажиллагааны хүрээ өргөжсөнөөс голлон шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Дээд шатны төсвийн байгууллагаас тус байгууллагын 2022 оны төсвийг 772,417.6 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 772,417.6 мянган төгрөгөөр баталсны 661,779.4 мянган төгрөг улсын төсвөөс, 84,033.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Гүйцэтгэлийг хүснэгт 2-т харуулав

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	81605- Эрүүл мэндийг дэмжих	2,156.3	2,156.3	-	100%
2	81801- Үдий цай хөтөлбөр	43,632.5	41,201.6	2,430.8	94.4
3	81816-Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	11,990.0	11,990.0	-	100%
4	81823-Боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээш	4,218.9	4,218.9	-	100%
5	81834-Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр	468,738.1	462,702.6	6,035.5	98.7%
6	83601-Нэмэлт олон улсын байгууллагаас олгоссон	10,000.0	10,000.0	-	100%
7	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	84,132.2	77,702.1	6,430.1	92.3%
8	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	57,302.3	52,684.8	4,617.5	91.9%
9	80112-Нийтлэг үйлчилгээ	31,348.8	31,348.7	1.0	100%
10	80226-Байр ашиглалтын үйлчилгээ	1,875.1	1,875.1	-	100%
11	80312-Сургалт семинар	937.5	937.5	-	100%
12	801806-Дотуур байрны үйлчилгээ	44,900.9	35,001.5	9,899.4	77.95%
13	81844- Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	9,381.0	9,381.0	-	100%
14	81848- Сурах бичгийн түрээс	1,804.0	1,525.7	275.3	84.5%
НИЙТ		772,417.6	742,725.9	29,691.7	96.1%

Төсвийн төлөвлөгөөнөөс 5,419.6 мянган төгрөгийн санхүүжилт дутуу олгогдож 24,272.1 мянган төгрөг хэмнэгдэж улсын төсвийн харилцах дансанд үлдсэн байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Наран сумын сургууль нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Миндүг Аудит” ХХК-ийн гүйцэтгэх захирал /МНБ, аудитор/ Б. Бүзмаа, аудиторын туслах Л. Золбоо нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын менежер С. Энхтөр, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер Г.Даваа, тус газрын Дарга, Тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Наран сумын сургууль нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 130/09 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагаас 1.5 хувиар буюу 8,171.7 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 5,720.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөлтийн үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1¹, 15.2.3²-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд газрын төлбөрөөс өөр хэтэрсэн зардал байхгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Наран сумын цэцэрлэг нь 2022 онд нийт 772,417.6 мянган төгрөгийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хуулийн 6.1.-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” заасны дагуу цаг хугацаанд нь ил тод байршуулахаас 27 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Наран сумын цэцэрлэгт завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн нийт 546,906.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 546,906.8 мянган төгрөгийн залруулга хийж 100 хувьтай биелсэн байна.

¹ байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

² сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	3	1,183.2	3	1,183.2	100%
Албан шаардлага	1	3,694.2	1	3,694.2	100%
Зөвлөмж	3	542,029.2	3	542,029.2	100%
Нийт дүн	7	546,906.6	7	546,906.6	100%

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 66,305.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 6,646.7 мянган төгрөгийн залруулга, 59,659.1 мянган төгрөгийн албан шаардлага, шилэн данстай холбоотой зөвлөмж өгөв.

5.1 Залруулга

Санхүүгийн үр дүнгийн тайлан болон мөнгөн гүйлгээний тайланд зардлыг 6,646.7 мянган төгрөгөөр илүү тайлагнасныг залруулав.

5.2 Зөвлөмж

5.2.1 Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудаст 2022 онд нийт 144 мэдээллийг ил тод байршуулахаас 27 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмыг хэрэгжүүлээгүй байна.

2. Өгсөн зөвлөмж

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах.

5.3 Албан шаардлага

Илрүүлэлт: Аж ажуй нэгж байгууллагатай холбоотой 52,920.6 мянган төгрөгийн худалдан авалт татварын цахим системд бүртгэгдээгүй, И-баримтаар нотлогдохгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтыг бүрдэлгүй, ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно, НӨАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т “бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”, 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын

асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй” заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтахгүй байх албан шаардлага хүргүүлсэн

Илрүүлэлт: Бараа материалын 2022.12.31 өдрөөрх тооллогын дүн санхүү байдлын тайлангийн дүн 6,738.4 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ”, 12.2.1 “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”, 20 дугаар зүйлийн 20.2 “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2.1-д “үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын зардлын тооллогыг жилд нэг удаа”, 2.2-д “түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа”, “эрх ба үүрэг”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Албан шаардлага		Үүнээс				Зөвлөмж	
					Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүү байдлын тайлан мөнгөн гүйлгээний тайлан зөрүүтэй	1	6,646.7			1	6,646.7			-	-
Дүн	1	6,646.7	-	-	1	6,646.7	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Шилэн дансны тухай хуулийн хугацаа хоцорч мэдээлсэн	1	-	-	-	-	-	-	1	-
ААН холбоотой зардал татварын цахим системд бүртгэгдээгүй.	1	-	-	-	1	-	-	-	-
Бараа материалын тооллогын дүн санхүү байдлын тайлангаас зөрүүтэй.	1	6,738.4			1	6,738.4			
Дүн	3	6,738.4	-	-	2	6,738.4	1	-	-